

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны нэгдүгээр сарын 3-ны 11 цаг 10 минутад эхэлж, 11 цаг 45 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 35 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Ж.Түмэндэлгэрийн өргөдлийг хянан шийдвэрлэх комисс томилон ажиллуулах	Ж.Түмэндэлгэрийн өргөдлийг хянан шийдвэрлэх комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах тогтоолын төслийг батлав.
2	Хулд сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Говь-Угтаал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлах тухай	Хулд сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаж, бүртгэлийг 2017 оны 02 сарын 01-ний өдөр, шалгалтыг 02 сарын 02-03-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв. Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Говь-Угтаал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх шаардлагатай тул буцаахаар шийдвэрлэв.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА